

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ЭНГЭТМЭЭР УХЛААНЫ ФАКУЛЬТЕТ

# ТҮҮЖ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ № 488 (14) 2002 он

RUSSIA



# Гарчиг

## Эрхэм уншигч Танаа

5

### Монголын түүх

1. П.Дэлгэржаргал. Мэнгу шивэй аймгийн угсаа гарлыг нэхэн сурвалжлах нь. 8
2. Д.Хүүхэнбаатар, П.Дэлгэржаргал. Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөний түүхийн асуудал. (XX зууны эхний хагас). 12
3. Д.Энхцэцэг. Үндэсний эв нэгдэл- тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн баталгаа болох нь. 18
4. Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь гадаадынхны үйл ажиллагаа. 23
5. З.Лонжид. Дундат иргэн улсаас Монголын тухай баримталсан бодлогыг нэхэн судлахуй. (1919 оноос хойш) 29
6. С.Отгонжаргал. XX зуунд Монголд гарсан хөрөнгөлөг ардчилсан хувьсгалын асуудалд. 34
7. Н.Хишигт. Монголын түүхэнд Барон Унгерний холбогдох нь /1921-1925/ 42
8. Б.Пунсалдулам. Монгол дахь Буриадын хурал. 51

### Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

1. Б.Ралгаа. Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн нь. 57
2. С.Түвшин. Ж.Цэвээний улс төр, нийгэм-эдийн засгийн үзэл баримтлалын тухайд. 68
3. З.Баасанжав. МУИС байгуулагдсан түүхээс. 73
4. Л.Ариунаа. Монголд өөрөө удирдах ёсны түүхэн уламжлал байсан уу? (Бодрол, тэмдэглэл). 78

### Байгаль хамгаалах түүхэн уламжлал

1. Ж.Болдбаатар, С.Дэмбэрэл. Монголчуудын байгаль орчноо хамгаалах зан заншил, хууль тогтоомжийн түүхэн тойм (Нэн эртнээс XX зуун). 80
2. Л.Чулуунбаатар. Ган зудын гамшиг, гэтлэн давах арга замын тухайд. 99

### Гадаад харилцааны түүх

1. Ута Шёне. 1920-иод онд Герман улсад суралцаж байсан монгол сурагчдад болон Лайпцигт хэвлүүлсэн монголын газрын зургийн түүхэнд холбогдох зарим тэмдэглэл. 104
2. Р.Төрдалай. Франц улсын Парис хотын монгол сурагчид /Түүхэн тэмдэглэл/. 110

### Түүх бичлэг

1. Удо Баркманн. Монголын түүхийн талаархи олон улсын судалгаа: Эзгүйрэл, улс төрийн ашиг хонжоо хоёрт идэгдсэн Монголын түүх. 114
2. Б.Пунсалдулам. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын тухай түүх бичлэгийн зарим асуудалд. 127

### Түүхэн газар зүй

1. Д.Сүхбаатар. Монгол орны түүхэн газар усны нэрийн тухай. 133

### Хавсралт

1. Түүхийн салбарыг төгссөн алдартнууд 137
2. Зохиогчдын товч танилцуулга 139

**Монголчуудын байгаль орчноо хамгаалах зан заншил,  
хууль тогтоомжийн хөгжлийн түүхэн тойм.  
/Нэн эртнээс ХХ зуун /**

**Доктор, профессор Ж.Болдбаатар /МУИС/  
Ахмад түүхч С.Дэмбэрэл**

Байгаль орчноо унаган төрхөөр нь авч үлдсэн улс орон манай ертөнцөд бараг үгүй гэж хэлж болно. Харин Монгол улс нүүдэлчдийн соёл иргэншлийг удаан хугацаанд хадгалж үлдсэний ачаар байгаль орчноо харьцангуй уугуул төрхөөр нь хадгалж хоцорсон цөөн тооны орны нэг юм.

Учир нь нүүдэлчин монголчууд байгалийн ивээл, эрхшээлд цаг ямагт амьдарч мянга мянган жил, бас өдөр тутам унаган байгальтай харьцаж ирсэн ард түмэн. Монголчуудын эртний шүтлэгийн хэлбэрүүд, ялангуяа онгон шүтэх ёс /тотемизм/ нь тэр чигээрээ хүн, байгалийн шүтэн барилдахуйг илэрхийлж байсан юм. Онгон шүтэх ёсны дараа гарч ирсэн бөөгийн шашин нь тэнгэр эцэг, газар эх хэмээн өргөмжилж, тэнгэрийг нар, сар, од, гаригийн хамтад, газрыг хөрс шороо, уул, ус, ургамал амьтан лүгээ ухааран ойлгож, тэд бүхнийг цогц байдлаар нь хүндлэн бишрэх үзлийг хүн ардаа төлөвшүүлж ирсэн бөлгөө. Бурхны шашин ч бөө мөргөлийг шахан гарч ирэхдээ монголчуудын байгаль орчноо шүтэн бишрэх тэрхүү гол санааг өвлөн авч, өөрийнхөө сургаал номлолд уялдуулан зохицуулсан юм. Ийнхүү монголчууд нэн эртнээс газар, ус, агаар мандлыг, тодруулан хэлбэл чимх шороо, ширхэг өвс, ганц амьтан, дусал ус, нэгэн агшинд амьсгалах агаар бүхнийг шүтэлцүүлэн барилдуулж, орчин үеийн дэлхийн шинжлэх ухааны экологи хэмээх ухагдахууныг бүрэн ойлгож, нандигнан хамгаалж ирсэн авай. Монголчууд өөрсдийгөө байгалийг эзлэн номхруулагч “хаан” хэмээн бардамнан сайрхаж байсангүй, харин түүнийг амьдралыг тэтгэгч журмын сайн “нөхөр”, хайрлан энэрэх, ариажуулан хамгаалах “эзэн” нь бид гэж үзэж, үлгэр домогтоо охьлон ширгээж, ончтой хэлэлцэн биширч ирсэн юм. “Цэцэн бэрийн тухай” Монгол ардын үлгэрт:

Баян, ядуу хоёр хүн зарга хийж, эзэн ноёндоо бараалхахад:

- Та хоёр “хамгийн тарган, хамгийн хурдан, бүхнээс эелдэг” юм юу болохыг мэдээд ир гэж тушаажээ. Цэцэн бэр хадам эцэгтээ:

- Бүхнийг тэтгэх газраас тарган нь үгүй
- Хаа ч хүрч сэтгэж, санаж бодох сэтгэлээс хурдан нь үгүй
- Зовлонг мартуулах зүүд манахаас эелдэг нь үгүй

гэж хэлж өгснөөр баяныг бэрийнхээ сийлсэн ухаанаар дийлсэн тухай өгүүлдэг. Бас нэгэн домгийг өгүүлбээс: Манжийн хаан охиноо залуу монгол ноёнд хатан болгон соёрхжээ. Охин нь нутагтаа эргэж ирэхэд нь хаан эцэг нь:

- За, танай хадам чамайг очиход юу бэлэг болгож өгөв гэж асуухад охин нь:

- Ус ургамал тэгш, ан амьтан элбэг, жигүүртэн шувуу халин ниссэн өндөр сарьдаг уул нэгийг бэлэглэлээ гэхэд хаан эцэг нь:

- Нүүлгээд аваад явчих аргагүй уул нуруу бэлэглэнэ гэдэг ёстой л чонын санаа мэт монгол ухаан даа гэж дуу алдсан гэдэг. Ийнхүү газар шороо, уул хангайн тухай домоглон өгүүлэхээс гадна “Ус-чандмань эрдэнэ” хэмээн залбирч, ардын билэг сургаалдаа цохон хүндэлж ирсэн юм. Монгол ардын ертөнцийн гурав хэмээх сургаалд:

Ургаж буй арц нэг ариун  
Уугиж буй хүж нэг ариун

## *Байгаль хамгаалах түүхэн уламжлал*

Урсаж буй ус нэг ариун хэмээн урсгал ус урсгал мөрнийг хамгийн ариун зүйлийн нэг гэж үзэж хүндэтгэж иржээ. Монголчууд рашаан хэмээх цэнгэг усны анагаах чадлыг хэрхэн тогтоосон тухай олон арван домог байдаг. Өдгөө Өвөрхангай аймгийн нутагт буй Хужиртын рашааныг Шунхлайн булаг гэж нэрлэж байсан бүлгээ. Тэр нутгийн нэгэн булгийн усанд доголлон гөрөөс өглөө болгон ирж хэвтсээр сүүлдээ илааршин эдгэрснийг нутгийн хөвгүүн Шунхлай ажиглаж, тэрхүү шидэт усыг нээсэн гэдэг. /14,12./

Монголчууд дунд агаар мандал, хөх тэнгэрээ бишрэн дээдлэх үзэл бас эртнээс дэлгэрчээ. Харийнхан ч Монголын номин цэнхэр тэнгэр, цэнгэг агаарт шунаж, өөрийн эрхгүй биширч ирсэн бөлгөө.

Бээжингээс ар Халхад байцаан шийтгэх ажлаар ирсэн нэгэн манж түшмэлийг буцах болоход монгол түшмэл эзэн хаанд бол, нөгөө түшмэлд ямар бэлэг таалагдаж болохыг тандтал:

- Болдогсон бол эндээс нэг тулам цэнгэг агаар, зүсэм хөх тэнгэр Бээжинд аваачиж, эзэн хаандаа бэлэглэх юмсан хэмээн хэлсэн гэдэг. Чингээд олныг эс өгүүлэн, монголчуудын байгаль хамгаалах зан заншил, шашин, хууль цаазны цогц уламжлалаас уншигч Танаа толилуулья.

### **I. Байгаль орчныг хамгаалах зан заншил, шашны уламжлал**

Монголчуудын байгаль орчныг хамгаалах зан заншил, шашны уламжлалыг эрдэмтэн судлаачид янз бүрээр ангилж үзжээ. Эл асуудлыг нэлээд ултай судалсан хууль зүйн шинжлэх ухааны доктор О.Амархүү: “Уламжлал болсон ёс заншлыг байгаль орчинд хандах хандлага, агуулга зарчим, арга билгийн хувьд энэрэл хүндэтгэлийн, хорио цээрлэлийн, сургаал номлолын, сүсэг бишрэлийн, ажиглалт танин мэдэхүйн гэсэн таван үндсэн ангилалд хуваан үзжээ”. /1,9-10/ Энэ ангилалд бүрэн тал өгч болох юм.

Үүнд: 1. Энэрэл хүндэтгэлийн уламжлал нь нэг талаас байгаль орчноо дээдлэн хүндэтгэл, ёслол үйлдэх, нөгөө талаас байгалийн хишиг өгөөжийг хүртэхдээ ариг гамтай хандах явдлаар илэрч байв.

Байгаль орчноо дээдлэн хүндэтгэл, ёслол үйлдэх уламжлалын гол гол зүйлийг товчоолон дурдвал:

- Цагаан сарын шинийн нэгэнд наран ургахаас өрсөж, хамгийн түрүүнд хан хурмастдаа мөргөн золгоно.

- Нар, сар, од эрхист онцгой хүндэтгэл үзүүлнэ. Нарыг бэлгэдэн хүрээ үүсгэн, дугуйран сууж, ямагт нар зөв эргэх, мандахын улаан нарнаар аливаа үйл эхлэхийг эрхэмлэн, нар, саран хээгээр улс гүрэн өнө мөнхөд бат оршихын, үүлэн хээгээр аз жаргалын бэлгэдлийг тус тус дүрслэнэ.

- Айлын эзэгтэй, өнөр бүлийн сайхан ээж бүсгүй хүн өглөө эртлэн босч, цай, сүүнийхээ дээжийг дөрвөн зүг, найман зовхист орших хангай дэлхий, уул ус, мандан гийх наран авхайд өргөж сүслэн залбирч ирсэн

- Цай, сүүнийхээ дээжийг байгаль дэлхийдээ зориулан сацал өргөх ёс нь цагаан сар, мал аж ахуй, амьдрал ахуйн бусад ёслолын /гүү барих, мал хөнгөлөх, гэр бүл болох, үр хүүхэд төрөх гэх мэт/ үед улам илүү ёс төртэй, өргөн агуулгатай болдог. Чингэж тэнгэр, уул, усанд сацал өргөхдөө: “Сайн зүгийн минь тэнгэр, саруул зүгийн минь заяа, гарахын гарзыг хааж, орохын олзыг нээн буулгаж хайрла” хэмээн шивнэн залбирна.

- Өндөр сарьдаг уул, их хайрханыг хүнд заах бол хуруугаараа чичилж заадаггүй, харцаа цэх, санаагаа талбиун болгож, гарынхаа алгыг дэлгэж, дээш харуулан эрхэм хүндлэл үзүүлэн заадаг.

## *Байгаль хамгаалах түүхэн уламжлал*

- Монгол идээний дээж-архи, дарс, нанчид хүртэхийн өмнө гурвантаа сэржим өргөхдөө дотроо: “Уул ус минь, ураг төрөл минь, үр хүүхэд минь” гэж зарим нутагт “Дээд тэнгэр, дэлхий ээж, дэргэдэх түмэн минь” гэж дотроо сүслэн залбирдаг. Яаж ч сүслэн залбирлаа гэсэн эх дэлхий, уул усандаа эхний сэржмээ өргөдөг нь нийтлэг бөгөөд хатуу тогтсон ёс болой.
- Монголын нүүдэлчид нутаг бэлчээр сэлгэн нүүж, шинэ нутаг усанд буухдаа өнгөтэй өөдтэйгээ шилж өмсөж, үс гэзгээ янзалж, гоёж гооддог зан үйл нь уул усны эзэн, лус савдагт хүндэтгэл үзүүлж байгаа хэрэг аж.
- Байгаль орчиндоо энэрэл хүндэтгэлтэй хандаж ирсэн ёс заншлуудын дотроос бүх нийтийг хамарсан, хамгийн илүү хүндэтгэлтэй, сүүлдээ төрийн ёслолын шинжтэй болсон зан үйл бол уул овоо тайх ёслол байв. Энэ ёслол нь овоо тахилгаас илүү өргөн цар хүрээтэй, үлэмж хүндэтгэлтэй зан үйл юм. Монгол нутагт уул овоо тайх зан үйл нь XIII зуун болоход хэдийнээ төрийн ёслолын шинжтэй болсон байв. Хан Хэнтийн Бурхан Халдун уулыг Чингис хааны үед Хамаг Монгол хийгээд Их Монгол Улс, нийт монгол туургатны сүлд уул болгон хүндлэн тахиж ирсэн түүхтэй. Энэ ёс бараг тасралтгүй үргэлжилсээр Олноо өргөгдсөн Монгол улсын үед “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-ийн “Тайх тахиглах ёслолын хууль”-иар хуульчлагдсан төрийн томоохон ёслол болон хувирсан байна. Эл хуулиар Богд хан хайрхан уул, Хан хэнтий, Отгон тэнгэр уулыг тайх тахилга үйлдлийг зун намрын дэлгэр цагт хийж байхыг хуульчлах, уг тайх тахилгын дэг жаяг, төрөөс оролцох, албаны хүн, гаргах хөрөнгийн тухай нарийвчлан заажээ. Үүнээс үзэхэд, уул овоо тайх ёслолыг Монгол нутгийн хамгийн гоц үзэсгэлэн төгөлдөр, түүхэн тэмдэглэлт газар хийдэг байсан байна. Энэ ёслол нэн эртнээс эхлэн XX зууны 30-аад он хүртэл үргэлжлээд, нэг хэсэг тасарч, XX зууны 90-ээд онд дахин сэргэж байна. Уул овоо тахиx ёсыг мухар сүсгийн үүднээс бус, байгаль орчноо хамгаалах чиглэл рүү нь гүнзгийрүүлэн хөгжүүлэх талаар орон нутгийн захиргааны байгууллагууд анхаарах хэрэгтэй байна.
- Монголчууд уул, усаа өргөмжлөн дээдлэхдээ хүний амьдралд хамгийн их хүндэтгэл буйлуулсан “Хан хурмаст”, “Хатан ижий”, “Амин голд ууссан ачит эхийн сүү” гэх зэрэгтэй зүйрлүүлсэн нэрийг оноож өгдөг. Жишээ нь: Богд хан, Хан жаргалант, Хатан Туул, Хан Хөхий, Алтан овоо гэх мэт. Тэр ч байтугай зарим уул усанд төрийн цол хэргэм өргөмжилж байжээ. Тухайлбал, Орхон голд “Түшээ гүн” цол өргөмжилж байв. Эдүгээ ч “Орхон Түшээ гүн” хэмээн нэрлэсээр буй. Түүнчлэн уул, усны оноосон нэрийг дэргэд нь буюу ойр орчимд нь хэлдэггүй, “Өндөр хайрхан”, “Алтай хангай”, “Далай ээж” гэх мэт хүндэтгэлийн үгээр төлөөлүүлэн ярилцдаг байсан нь мөн л байгаль дэлхийдээ үнэнхүү элгэмсүү хандаж ирсний илрэл мөн.
- Монголын говь нутагт амьдардаг ард олон заг, хайлаас, сухай модыг эрхэмлэн хүндэтгэдэг бол хангай нутгийнхан бургас, хус, хуш, арц, яргай зэрэг төрлийн модыг илүү хүндэтгэн хайрлаж иржээ. Харин нутаг уснаас хамааралгүйгээр нийтлэг байсан нэгэн уламжлал бол ганц нэгээр ургасан онцгой содон мод, хэсэг бусад бут модыг /их төлөв, ийм модыг нутаг нутагт адилхан “Зуун мод” гэж нэрлэдэг, бас “Мянга тооройн булаг” гэх мэтээр өсгөж нэрлэнэ/ “ихэд хүндэтгэн хайрлаж байсан зан үйл юм. Иймэрхүү онцгой содон модыг “удган мод” гэх мэтээр нэрлэн, хадаг яндар уян шүтэж, мөчрийг авах, хугалж гэмтээх байтугай, зарим тохиолдолд ойртож очихыг ч цээрлэж иржээ. Энэ нь сүсэг бишрэлийн шинжтэй мэт харагдавч, ганц болон цөөн мод үрээ ойр орчимдоо хаяж, олшрон үржих нөхцлийг хангах холын хаялгатай заншил юм.
- Хус модыг хүн, малд буян заяа сайтай хэмээн сүсэглэж, түүнийг гэрийн багана, эмээл, уурга хийх төдий хэрэгцээнд ашиглаж ирсэн, мөн арцыг ариун тансаг

## *Байгаль хамгаалах түүхэн уламжлал*

хэмээн дээдэлж, үндсээр нь айраг, сүүний халбага, цацал, хурдан морины хусуур хийх зэрэг хүндэтгэж ханддаг заншил өдгөө ч мартагдаагүй хадгалагдсан байна.

- Сүм дуганын бараа харагдаж, дун бүрээ хэнгэрэг цангийн дуун сонсогдох газраас мод огтолж, газар хөндөхийг хориглож байсан нь байгаль орчноо хамгаалах төдийгүй, шашин номыг хүндэтгэж байсан хэрэг.

- Монгол хүний эрхэмлэн дээдэлдэг нэгэн шүтээн бол цэнгэг ус, рашаан булаг юм. Тийм учраас усыг “Чандмань эрдэнэ”-тэй зүйрлүүлэн нэрлэж, булаг шанд, гол горхи, нуур цөөрмөө хамгаалж, хайрлаж ирсэн бөлгөө.

- Чоно буга зэрэг амьтнаас өөрсдийгөө гаралтай өвөг дээдэс минь /Энэ тухай шашин, сүсэг бишрэлийн уламжлал гэсэн хэсэг дэлгэрэнгүй өгүүлнэ. Зох/ гэж, шувууг хан хурмастын гаралтай хэмээн тусгай хүндэтгэл үзүүлнэ. Тухайлбал, начин шонхорыг боржигин овгийн шүтээн, ангирыг лам шувуу гэж хүндлэн, хунг гоо эрхэмсэгийн бэлгэ тэмдэг гэж үзэж ирсэн.

- Нүүдлийн шувууд ирэхэд цай, сүүнийхээ дээжийг өргөн аль болохоор удаан, тэнгэрийн хаяа нүд үл үзэх болтол хүндэтгэж өнгөрүүлнэ. Харин буцаж буй шувууны хойноос цацал өргөх боловч, удаан харж зогсохыг цээрлэнэ.

- Алс газар явахдаа угаасан уснаасаа амсаж, урсгал уснаас нь духандаа хүргэн адис аваад мордоно.

Монголчууд байгалийн хишиг өгөөжийг хүртэхдээ аригч хямгач хандаж байсан ёс заншлыг хураангуйлан үзвэл:

- Монголчууд таван хошуу малынхаа аясаар өвсний соргог, усны тунгалаг, уулын нөмөр бараадаж, цаг улирлын дагуу нутаг солих “хаваржаа-зуслан-намаржаа-өвөлжөө” гэсэн нүүдлийн амьдралын нэгэн бүхэл бүтэн эргэлтийг буй болгосон нь ус, бэлчээр, бүхэлдээ байгалийн хишгийг зохистой хүртэх нөхцлийг бүрдүүлсэн хэрэг юм.

- Түлшинд зөвхөн өгөршиж хатсан мод, бут, унасан гишүү хэрэглэнэ. Модыг угаар нь тайрч аваад, газрын чийгийг ууршуулахгүй хэмээн хожуул дээр нь шороо асгана.

- Бут, ургамалыг хүн малын тэжээлд зориулан түүхдээ тухайн бутны 30-40 хувийн үндсийг тасдалгүй авдаг, жимс, жимсгэнэ, эмийн ургамалыг үндсээр нь сугалалгүй тасдан авдаг, мөөгний хүрээг цөлмөж хоосолдоггүй заншилтай байв.

- Ан амьтны үржих төлжих, үс арьс тарга хүч гүйцэх цаг хугацааг гүнзгий танин мэдэж, зөв сонгон авч, чухамхүү тэр л цаг үед ан ав хийдэг, ангийн мах, арьс зэрэг олзвороо нарийн зориулалтаар, ариглан хэмнэж хэрэглэж ирсэн.

- Анчид ан амьтныг хөөж үргээж буудахаасаа илүү сэм гэтэж, ойртон очиж шилж сонгон агнахыг эрхэмлэнэ. Ойртож очиход зориулж морь, тэмээг зориуд сургана. Сургасан малыг “түлхдэг мал” хэмээн нэрлэнэ. Агнах андаа ойртон очсоноор эр, эм, хөгшин залуу, тарган, туранхай, арьс үс гүйцсэн эсэх зэрэг тодорхой шинж тэмдгээр нь ялган мэдэрч, заазалж агнах боломж анчинд өгдөг сайн талтай.

- Гөрөөчид амьтны үр төл, зулзага, хээл нь хүндэрсэн буюу нялх төлөө дагуулсан, мөн ичээндээ байгаа амьтан, хурж чуулж буй амьтад /могойн чуулган зэрэг/, сүргийн манлай, сүргийн доторхи гойд содон амьтан, биедээ хужир шингээсэн тарвага, дуудаж байгаа буга зэргийг агнадаггүй уламжлалтай байсан.

- Нялх, бага хүүхдэд зоос, чулуу, үнэгний хамар, хүрэл эдлэл, чонын шагай, буга, гахайн соёо, дун, арслан, барс мэт хүчитний зураг, бууны дүрс, ангийн биед тогтсон сум, заг улаан болон алтан харгана, үнэгний дүрс, цагаан үен, хүдрийн шагай, загасны хүзүү, нуруу зэргийг зүүж өгнө /15,118/. Энэ нь хар нялхаасаа байгаль орчноо хамгаалах, хүндэтгэх ухамсар суулгах зорилготой. Дээр дурдсан бүхэн нь монголчууд ан агнуурын соёлыг гойд эзэмшсэнийг илтгэнэ.

**2. Хорио цээрлэлийн уламжлал** нь ард зон байгаль дэлхийтэй харьцахдаа үр хүүхэддээ цээрлэвэл зохих, үл болох зүйлийг авах, гээхийн

## *Байгаль хамгаалах түүхэн уламжлал*

ухаанаар шүүн тунгааж сургах, эерэг бүхнийг уламжлуулан үлдээх гэсэн олон талт, цогц үйл ажиллагаа юм. Энэхүү уламжлалын гол нийтлэг зүйлүүдийг товчоолбол:

- “Тэтгэх тэнгэрийн заяа хаяна”, “Хан хурмаст хилэгнэнэ”, “Лус дсгширно” хэмээн үзэж, тэнгэр огторгуйг муу хэлж, хараахыг хатуу цээрлэнэ.
- Нар өөд юм уу, алтан гадас одыг харж морь харах, тэргэл сарны гэгээ тусах газар унтах, нар, сар хиртэх үед идэж, ууж хэвтэхийг цээрлэнэ.
- Байгалийн тогтоц, бүрдэл, унаган төрхөөрөө нэн өвөрмөц, ховор амьтан, ургамал бүхий газар, үзэсгэлэн төгс нутаг, уул усыг “догшин хайрхан” хэмээн сүрдэн сүсэглэж, хөрс шороог нь хөндөх, чулуу хөдөлгөх, ургамал өвс таслах, мод огтлох, ан гөрөө хийхийг чандлан хориглодог байжээ. Хэрэв ийм үйлдэл хийвээс лус, савдаг хилэгнэж, түүний хорлолд өртөж, хүн, малын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд гай түйтгэр учирна гэж хүмүүс багаасаа итгэн үнэмшдэг байв.
- Амьд байгалийн сэргэн төлжих хавар, зуны дэлгэр цагт, өвс ногоо ургах үест газар шороог ухаж сэндийчих, үр жимс сонгино, эмийн ургамлыг хамаа намаагүй авахыг цээрлэж ирсэн.
- Ундарга угшил нь татрахаас болгоомжилж, гол горхи, булаг шандны эх болон эрэг хавийн мод, буцыг огтлохыг хатуу хориглодог байв.
- Гол мөрний эрэг, гольдролыг ухаж, өөрчлөхийг хориглож, булаг шандны эхийг хөндөх, хамаа намаагүй зайдагнахаас аль болохоор зайлсхийнэ. Тогтмол усанд бие, хувцас угаахыг цээрлэнэ.
- Усанд сүү, цагаан идээ оруулбал сүүн тэжээлт бус, усны амьтдад хорлолтой, хилэнцтэй хэмээн үзнэ.
- Усны ойролцоо мал, амьтан төхөөрөх, усанд улаа /цус/ оруулахыг цээрлэдэг.
- Ус горхи, рашаан, булгийн эх, салхины урсгал зүгт угаадас, бохир зүйл асгах, хөг үнс хаях, бие засах, гэр бараа барихыг хориглоно.
- Монголчууд шувууг “тэнгэрийн амьтан” хэмээн нэрлэж, хүндлэн хайрлаж, шувууны үүр, ичээ зусланг хөндөх, ангаахай дэгдээхэйг оролдохгүй байхыг үр хүүхэддээ сургана. Шувуу гоц мэдрэмтгий амьтан учир өндгөө голохоос нь болгоомжлон, үүрэнд нь сүүдэр тусгахыг хатуу цээрлэдэг. Ялангуяа тогорууны өндөг, дэгдээхэйг хөндөхгүй байхыг эрхэмлэнэ. Хэрэв хөндвөл тогоруу төмөр дөрөө сэтэртэл хараана хэмээн цээрлэнэ.
- Хойлог шувууны мах онцгой эмчилгээний чанартай учир хайрлан хүндэтгэж хамгаална. Энэ шувуу байгаль дэлхийн хамгийн амт чанар бүхий сөлтэй эмийн ургамлыг түүж иддэг. Цус тогтоож шарх, сорвийг тун амархан анагаана. Хойлогны махыг нэг л идвэл тэр шувууны анагаах чадвар хүний биед шингэдэг учир дайн, байлдааны үед хойлогийн мах идсэн гэдгээ машид нууцалдаг байсан гэдэг. /15,43/
- Алтайн аргалыг зөвхөн аз хийморьтой хүнд бараагаа харуулж, баярлуулдаг амьтан хэмээн аль болох агнахаас цааргална.
- Монгол хүн могой алахыг ихэд цээрлэдэг нь зөвхөн урт настайг нь хүндлэх төдийгүй, байгальд тустай, байгалийг зохицуулдаг ер бусын чанарт нь болдог. Монголчууд урт настай амьтны амьдралын хэвшлийн талаар олон сонирхолтой зүйл ажиглагддаг нь ердийн үзэгдэл. Тухайлбал, могойн чуулга нэн сүртэй агаад хэр баргийн хүн очихооргүй газарт болдог. Тийм чуулгыг үзсэн хүн ховор хэдий ч үзсэн хүний яриаг сонссоны хувьд гайхах, сонирхох хосолж байсан. Гэхдээ могойн чуулга болох нь нутаг усны хүмүүст мэдрэгддэг. Хэрэв могой олон цөөнөөрөө нэг зүгт явах нь

## *Байгаль хамгаалах түүхэн уламжлал*

ажиглагдвал тэрхүү чуулга болох бөгөөд дараа нь байгаль орчинд таатай байдал бий болно. Ямар нэг тохиолдлоор чуулга саатах, эсвэл чуулсан үед нь могойг бөөнөөр нь хорлож устгавал тэр орчин болон устгасан этгээдэд нэн тааламжгүй учрал тохиолддог байна. Иймээс могой алахыг цээрлэнэ.

- Амьтны ороо нийлүүлгийн үе, төрөх цаг үед нь агнах, үүр ичээнд ус цутгах, ан амьтныг хомрогolon буудах зэргийг ихээхэн нүгэлтэй үйлдэл хэмээн хэвшиж заншсан байна.
- Олноороо ан гөрөөнд явахдаа хүндэтгэлийн ёс жаяг үйлддэг, хэрэв зөрчвөл зан заншлын төдийгүй, хууль цаазны цээрлэл хүлээдэг байжээ.
- Ахмад анчдын яриа, тэмдэглэлээс үзэхэд, манай өвөг ан ав хийхээр мордохдоо товросон өдрөө урьдаас нийтэд зарлан мэдээлдэггүй, зөвхөн өөр хоорондоо ойлголцох тэмдэг болгож, адууны хомоол солилцдог, анд явж байхдаа хэрүүл маргаан өдөөх болтугай, хараалын үг хэлэхээс цээрлэдэг заншилтай. Тэр ч байтугай агнах ан амьтнаа оноосон нэрээр нь нэрлэхээс цээрлэж, чоныг "хээрийн нохой", "боохой" хандгайг "хавтгай эвэрт", үнэгийг "малгай" гэх мэтээр хүндэтгэн нэрлэдэг. Ангийнхаа олзыг "хангайн хишиг" хэмээн нэрийднэ. Анчин хүнд 108 цээрлэл байдаг гэнэ. Байгальтай харьцаж хандах хорио цээрлэлийн ёс заншил эцсийн дүндээ байгаль хамгаалах сэтгэлгээ, соёлыг хувь хүнд төлөвшүүлж, улмаар монголчуудад нийтэд нь тийм ухаан суулгах алс хэтийн бодлогын нэгэн илрэл болж ирсэн гэж зарим судлаачид үзэж байгаад бүрэн тал өгч болох юм. /1,18/

**3. Сургаал, номлолын уламжлал** нь монгол хүн элэнц хуланц, диван галавын үеэс эх дэлхийдээ нэн ойр байж, ээнэгшин дасч, түүний жам хуулийг ойлгон ухаарснаар байгаль орчин, газар, усаа хэрхэн хайрлаж, аригч хямгач ашиглахын арга ухааныг хойч үедээ сургаж номлож, өдөр тутмын амьдралд нь ягштал хэвшүүлж ирсэнээр тодорхойлогдоно. Тэрхүү уламжлалын шилдгийг товчоолбол:

- Манай монголчууд газар эхээ амь гол шигээ хайрлаж, газрын судас нь амьдралыг тэтгэдэг гэдгийг үр хүүхэддээ ухааруулан ойлгуулж иржээ. Иймээс шинэ нутаг усанд буух, морь малын уяа, хашаа хатгах, аргамжааны гадас зоох, худаг ухах, газар хадгалахдаа ямагт ерөөлийн үг хэлж, арц хүж уугиулж сан тавьдаг, нутаг сэлгэн нүүхдээ шон, гадсыг сугалан авч, нүхийг шороогоор дардаг, гэрийн буурь, хот, хороогоо цэвэрлэж, цэмцийлэгдэг ёс заншилтай.
- Ургаа мод огтолбол тэрхүү мод сүүн нулимсаар энэлэн хайлж, огтолж хэрцгийлсэн хүн насан турш хангайн хишиг, сүү цагаан идээгээр дутмаг явна хэмээн хойч үедээ сургамжилж иржээ.
- Ой хээр газар, ялангуяа хавар гал ноцоохдоо тачир, гол төлөв хад чулуу, сайр, элс бүхий газрыг сонгон авч, "Хан эзэндээ ам гарахгүй, хангай дэлхийдээ түймэр тавихгүй" гэж андгайлаад, хэтээ цахиж галаа асаана. Явахдаа галаа унтраагаад, түүний баталгаа болгож, унтарсан гал, үнсэн дээр хуурай өвс тавьж явдаг туйлын нягт нямбай, хянуур зан заншлаа үеийн үедээ уламжлуулж ирсэн юм.
- Сургаал номлолын уламжлалыг хүн ардад түгээн хэвшүүлэх нэг гол хэрэгсэл нь үлгэр, домог, дуу, ерөөл, магтаал, таавар бодлого, зүйр цэцэн үг, жороо үг зэрэг арвин баялаг аман зохиол, түүнчлэн ардын тоглоом, наадгай байжээ. Жишээлбэл: үлгэр, туульс, домог, ямагт өгөөмөр баян хангай хишгээ хайрласан байдлаар өгүүлэгдэнэ. Уул усаа өргөмжилсөн өдий төдий ерөөл магтаалууд бий. үүнээс тун алдартай нь "Алтай Ханы



магтаал”, “Богд Дүнжингаравын магтаал”, “Отгон тэнгэрийн сангийн судар”, “Хан Хөхийн магтаал” зэргийг нэрлэж болно. Зүйр цэцэн үгэнд “Уусан ус рашаан, унасан газар алт” гэх мэтээр сургамжилна. Мөн жороо үгэнд:

Хоёр уулын хооронд хоргой цэцэг

Цэцгэнд нь цэгээ алт

Алтанд арвин хэлхээ

Хэлхээнд нь хээ хуар

Хуаранд нь хунтар илжиг

Илжгэнд эгэл боол

Боолонд бор галуу

Галуунд газар ус

Усанд нь уул монгол /З.XIII/ хэмээн байгаль орчноо хамгаалахаас аргагүй байдлаар ончтой сургаж байв.

Сургаал номлолын уламжлал нь нийгэм, хувь хүнд байгаль орчныг хамгаалах сэтгэлгээ соёл төлөвшүүлэх өвөрмөц арга болж, хөгжин баяжсаар хүрч ирсэн байна. Энэхүү уламжлалыг хэвшүүлэх арга ухаан нь дан ганц эрхэлж буй ахуй, амьдралаас урган гарч буйлан төлжиж байсангүй, бас үе үед дэлгэрэн хөгжсөн төрөл бүрийн шашин шүтлэгтэй амин шүтлэгтэйгээр сүсэг бишрэлийн арга ухаанаар дамжиж хүний ой тойнд хүрч байсан юм.

**4. Шашин сүсэг бишрэлийн уламжлал нь монголчуудын байгаль хамгаалахтай холбоотой эртний шүтлэгийн хэлбэрүүдийн үлдэцээс эхлээд ялангуяа бурхны шашны номлол, ёс жаяг нь ардын зан заншилтай харилцан уусаж өвөрмөц хэм хэмжээ болон тогтсоноор тодорхойлогдоно. Зарим гол гол зүйлүүдийг багцлан дурдвал:**

- Эртний монголчуудын байгалийн догшин ширүүн үзэгдэл, үйл явцыг сөрөн зүтгэж, унаж босч явахдаа амь зуулгын төлөөх эл тэмцэлдээ тус дэм, ээлээ өгсөн тэр зүйл, байгаль орчин дахь аль нэг содон сонин үзэгдлийг эн тэргүүнээ онцлон шохоорхож, яваандаа бишрэн шүтэх болсон. Тухайлбал, эртний монголчуудын хувьд мод, чулуу, нар, сар зэргийг илүүтэй шүтэж байв. Эртний шүтлэгийн нэн эртний хэлбэр, бүр тодорхой хэлбэл, хүн хүрээлэн буй орчныхоо аль нэгэн модон тогтоц, илрэл бүхий юмс үзэгдлийг бусдаас онцлон салгаж, түүндээ бишрэх шүтэх үзэл санаа-цалигчлалын ёс /фетишизм/ сонгодог хэлбэрээрээ биш ч гэсэн тодорхой зарим утгаараа эдүгээ хүртэл хадгалагдаж байгаа нь байгаль хамгаалах сүсэг бишрэлийн шинжтэй уламжлал болон үлдсэн байна. Жишээлбэл, өнчин хайлаас, удган мод, оройн ганц мод, захын ганц мод тэргүүтэн бусдаас содон газарт ганц нэгээр ургасан буюу сүрлэг том саглагар модыг шүтэж, тэр орчмын газрыг хайрлан хамгаалж ирснийг өмнө өгүүлсэн. Чулуу шүтэж байсны нэг улбаа бол уул давааны хөтөлд дөрөө мултлан чулуу авч тэрхүү хөтлийн өндөрлөг хэсэгт их төлөв босгосон овоонд өрөөл залбирлын үг хэлж өргөдөг ёс юм. Аль ч нутагт явсан монгол хүн тэр ёсыг заавал гүйцэтгэнэ. Бас харь газар одогсод нутгийнхаа чулууг хадганд боон өвөртөлж, нутаг усаа дурсан санах бүрдээ түүнийг гарган үзэж, сэтгэлээ тайтгаруулаад нандигнан хадгалсаар буцаан авчирдаг ёсон буй.
- Байгаль дэлхийн бүх жамыг амьд, амь даагч эзэнтэй гэж үзэх төдийгүй, үгийн хүч, үгийн шидээр дамжуулан тэдэнд нөлөөлж хүсэл зоригоо ойлгуулж, зорилгодоо хүрч болно хэмээх үзэлд хүрсэн нь дом шившлэгийн ёсыг /смаги/ бий болгожээ. Эртний шүтлэгийн энэ хэлбэрийн үлдэгдэл өдгөө ч ямар нэг хэмжээгээр байсаар буй бөгөөд байгаль орчныг хамгаалахад зохих нөлөө үзүүлж байна.

## *Байгаль хамгаалах түүхэн уламжлал*

зэрэг тусгай зориулалтаар хийдэг. Энэ бүхэн нь хүн ард хангай дэлхийдээ сүслэн биширч, хүндэтгэл өршөөл эрж буйн илэрхийлэл болж иржээ.

Шашин, сүсэг бишрэлийн уламжлал нь олон мянган жилийн улбаатай, байгаль хамгаалах, хайрлах үзэл эртний шүтлэгээс эдүгээгийн бурхны шашны сургаалд гол цөм нь болж уламжлагдаж, шинэчлэгдэж ирсэн түүхтэй.

**5. Ажиглалт, танин мэдэхүйн уламжлал нь** монгол малчны олон үеийн турш байгаль орчноо ажиглаж, танин мэдэж, түүнийгээ уламжлуулан өвлүүлж ирсний өгөөж үр дүн юм. Олон жилийн ажиглалт туршилт нь нөр их мэдлэг, туршлагын сан болж баяжин хөгжсөөр сүүл сүүлдээ одон зурхайгаар давхар батлагдах болсон байна. Ингэж яваандаа шинжлэх ухааны танин мэдэхүйн үндсийг бүрдүүлжээ. Монгол хүн байгаль орчноо өөрийн бие, сэтгэлээр, эрхлэж аж ахуй-таван эрдэнэт мал сүрэг, ан амьтны үйл хөдлөлөөр, тэнгэр эрхисийн хувирал өөрчлөлтөөр танин мэдэж, шинжлэх ухааны үндэстэй гэж хэлж болохуйц таамаглал, мэдлэгийг буй болгожээ. Үүнд:

1. Монголчууд нар, сар, од эрхис, салхины аяс, манан будангийн шинж зэргээр байгаль цаг уурын өөрчлөлтийг шинжиж иржээ. Тухайлбал:

- Намрын дунд сарын арван тавны шөнө турш хэд хэдэн уулын оройгоос тэнгэр дурандаж, ирэх өвлийн цаг агаарын байдлыг урьдчилан товлох,
- Бүтэн жарны давталтаар хошуу нутгийн цаг уурын зураглал гаргах, /Тэрхүү зураглалд тэр хөндийн салхи тим улиралд хаанаасаа хэдэн удаа салхилдаг, тэр уулын гуу, жалганд хэр хэмжээний цас хунгарладаг, чухам аль зүгээсээ жаварладаг гэх мэтийн нарийн зүйлийг тусгаж байв./
- Тэнгэрийн хаяа улайж нар шингэвээс маргааш сайхан өдөр болох,
- Салхи урдаасаа урьвал тэнгэр эвгүйтэх,
- Нар сар хүрээлсэн бол хүйтрэх
- Нар хэт цоновоос ширүүн бороо орох,
- Манан будан ихтэй байвал мөөг сайн ургах гэх мэт.

2. Монголчууд мал, ургамлын үйл хөдлөлөөр байгаль, цаг уурын өөрчлөлтийг урьдаас ажиглан танин мэдэж ирсэн байна. Жишээлбэл:

- Сарлаг үхэр уулын хяр өндөр газраар, адуу бол талаар тайван бэлчээрлээд байвал тэнгэр дулаан сайхан байхын шинж тэмдэг,
- Үхэр бэлчээрт гарах дургүй хотондоо хоргодоод байвал удахгүй хүйтрэхийн шинж,
- Тэнгэр муухай байхад унага, тугал эрхлэн оодогнон гүйвэл онгойхын дохио,
- Хараацай шувуу дээгүүр нисвээс тэнгэр сайхан байхын тэмдэг,
- Хөхөө шувуу эрт донгодвол зуны улирал богино болж, эрт намаршихын шинж,
- Хулгана, зурам хөөө их авбал хүйтэн өвөл болохын ёр,
- Тарвага эрт ичиж, ичээгээ дүүрэн бөглөвөл хатуу хахир өвөл болохын дохио,
- Өвс ургамал эрт гандаж эхэлбэл, мөн говь, хээр талын амьтад, цагаан зээр, хулан дов толгод, уулархаг нутаг бараадаад байвал өвлийн улирал цагаасаа өмнө эхлэхийн шинж тэмдэг,
- Чонын от ороо эрт эхэлбэл ирэх хавар зөөлөн орохын шинж тэмдэг,
- Нохой, муур гийнаж гаслах, гэр орноосоо дайжиж хөндийрөх, мал сүрэг майлалдах, мөөрөх гэх мэт хэвийн бус байдал өдөр дараалан давтагдаад байвал газар хөдлөх, үер болох зэрэг байгалийн гамшиг, аюул удахгүй бий болохын дохио гэх мэт.

## ***Байгаль хамгаалах түүхэн уламжлал***

3. Монголчууд өдөр тутмынхаа гэр ахуйн ердийн амьдралын үзэгдэл, өвгөд хөгшидийн бие махбодид гарах хэвийн бус өөрчлөлтөөр ч байгаль, цаг агаарын байдлыг урьдчилан таамагладаг заншилтай. Үүнд:

- Тогооны хөө улайрч ямаараад байвал тэнгэр зохирч дулаарахын шинж,
- Салхи намуун үед утаа эгц дээшээ гарч байвал тэнгэр сайхан байх, тэр хавьдаа хорголзоод байвал хур бороо элбэгшихийн дохио,
- Намаг цөөрмөөс эвгүй үнэр гарах, гаанс бөглөрч бохь шаржигнах, гэрийн хялгасан бүслүүр, оосор бүч чангарч чивчрэх зэрэг нь цөм тэнгэр муухайрахын шинж,
- Хөгшдийн хүзүү сээр хөших, хөл гар даарах, бэртэнгэ өвдөх байдал илэрвэл тэнгэр эвгүй аашлахын ёр гэх мэт

Танин мэдэх уламжлалын гол онцлог нь хүн, байгаль хоёр хүйн уялдаа холбоотойгоор бие биедээ харилцан татагдаж, нэг нэгнээ тулж түшиж ирсэнд оршино.

Хэдийгээр монголчуудын байгаль орчинд хандаж ирсэн хандлага, агуулга, зарчмыг дээр дурдсан таван ангилалын дагуу тус бүрээр нь зааглан хураангуйлж болох боловч, өөр хоорондоо амин шүтэлцээтэй учир зарим талаараа энэрэл хүндэтгэлийн шинжтэй байхад нөгөө тохиолдолд сургаал номлолын, эсвэл сүсэг бишрэлийн чанартай өргөн утга, агуулга бүхий зан үйл олонтой байна. Ийм учраас уг зан үйлийн аль тал нь илүү давуу болохыг шинжин тэр ангилал руу нь оруулах зарчим баримталсан болой.

Бүхэлд нь базаж хэлбэл, нүүдэлчдийн соёл иргэншил нь нийгмээс байгаль орчинтойгоо зохицож амьдрах бүхэл бүтэн арга ухаан, соёлыг бий болгосон нь нэн тодорхой харагдаж байна.

### **II. Байгаль хамгаалах хууль цаазны уламжлал.**

Монголчуудын дээд өвөг болох Хүннү гүрний үеэс байгаль хамгаалах асуудал төрийн бодлогын хэмжээнд тавигдаж эхэлсэн хэмээн үзэж байна. Хүннүгийн төр улсыг МЭӨ 209 онд үндэслэсэн Маодунь шаньюй “Газар бол улсын үндэс” гэсэн үзэл баримтлал буй болгож, нутаг, усаа хайрлан хамгаалах цааз зарлиг гаргаж байжээ. Уул ус тайх тахиж ёс ч энэ үеэс эхэлж, төрийн шинжтэй ёслол үйлдэж байсан байна. Тухайлбал, Хүннү нарын их тахилгын уламжлалыг үргэлжлүүлэн, Сүмбэ /Сяньби/ улсын хаан Таньшихуайн /Мэ 131-181 он/ үед Жаоле гол /Шар мөрөн/ хэмээх газар очиж тахилга үйлддэг байсан бол хожмын улсууд Отгонтэнгэр, Баатар Хайрхан зэрэг уулсыг тахиж байсан тухай сурвалж бичигт тэмдэглэгдэн үлджээ. Нутаг усыг дархлах явдал бүр эртний улсуудаас улбаатай бололтой. Зүүн өмнөд Монгол, Умард Хятадын нутаг дээр тогтнож байсан Кидан улсад /МЭ 907-1125 он/ цаазтай газар ан хийгсдийг шийтгэх тухай хааны зарлиг 1041 онд гаргаж байжээ.

1206 онд Монголын тулгар төр тогтож, Их Монгол улс байгуулагдсан үеэс байгаль хамгаалах хууль цаазны нэгдмэл тогтолцоо бий болж эхэлсэн байна. Энэ үеийн гол хууль бол “Их Засаг” хууль юм. Эл хууль нь нийгмийн нэг төрийн харилцааг зохицуулсан бус, харин олон төрийн харилцааг зохицуулсан нэгдмэл хууль цааз байжээ. Бидний үед уг хууль бүрэн эхээрээ ирээгүй, хэсэг бусаг заалтууд үлдэн уламжлагдаж иржээ. Гэсэн хэдий ч “Их Засаг” хуульд байгаль хамгаалах талаар дараах чиглэлийн асуудлууд хуульчлагдан зохицуулагдаж байжээ. Үүнд:

1. Газар нутгийг онгон төрхөөр нь хадгалах, цэвэр ариун байлгах, газрын хөрс бэлчээрийг зүй зохистой, арвич хямгач ашиглах асуудлыг хуульчилсан байна. Тухайлбал, Чингис хааны зарлигт “Хөрс шороог алдаж, өвс бэлчээрийг хохируулахыг хориглоно.” /5.22/, “Газар дээр сүү буюу идээ цагааны зүйл асгаж

## *Байгаль хамгаалах түүхэн уламжлал*

болохгүй, тэрчлэн хотон дотор шээхийг цээрлэгтүн. Энэ бүгдийг зөрчвөл даруй цаазлагтун" /5,27/ гэх мэтээр заасан нь байгаль орчныг хамгаалах өргөн хүрээтэй асуудлын дотроос нүүдэлч малчдын амьдралын эх үндэс-газар, бэлчээрийг эн тэргүүнд үзэж, түүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна. Энэ нь урьд өмнө заншлын эрхийн хэм хэмжээгээр зохицуулагдаж байсныг хуульчилсан хэрэг болой.

2. Монголчууд амьд амьтан бүхнийг цангаа тайлагч усыг чандмань эрдэнэтэй зүйрлэн дээдэлж, бохирдуулахгүй ариун тунгалагаар байлгахыг эрхэмлэн төрийн хуулиар зохицуулж өгчээ. Уг хуульд голын усанд хувцасаа угаах, бохирдуулахыг чанд хориглосон заалтууд олонтаа тааралдаж байна. Жишээлбэл, "Хөх усанд ... шээвэл цаазлагтун" /5,27/ гэж заажээ. Эрх зүйн энэ ойлголтыг хүүхдэд багаас төлөвшүүлдэг учир жирийн амьдралын хэм хэмжээ болон төлөвшдөг.

3. Ой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх асуудлыг хуульчилж өгсөн байна. Тухайлбал, "гал алдах, түймэр гаргаваас гэр орноор нь цаазаар авсугай" /5,27/ гэж зааснаас гадна бас нэг өөр хувилбарт: "Өвс ногоорсон хойно газрыг нүхэлсэн ба гал алдаж бэлчээрийг шатаасан нэгэн гэрийг ална" /6,44/ гэжээ. Эдгээр заалтад буй "цаазална" гэсэн үг нь хатуу шийтгэх гэсэн утгатай бөгөөд харин сүүлчийн "ална" гэсэн үг нь он цагийн элэлд хэн нэг нь "цаазална" гэсний утгыг "ална" гэж ойлгож буруу хэрэглэснээс болсон болов уу.

4. Монголчуудын аж ахуйн хавсрага, цэргийн сургуулийн ур чадварын илэрхийлэл болж байсан ан авыг зохион байгуулах, ан амьтныг зохистой агнах, хамгаалах асуудлыг хуульчилсан байна. Үүнд: "өвлийн анхны их цаснаас эхэлж, дараа хавар ногоо соёолтол монголчууд их ав талбиж бөхөн, буга, чихтэй /хулан/ зэрэг араатныг авлана" /6,44/ гэсэн ан амьтныг авлах хугацаа тогтоосон шинжтэй заалт тааралдаж байна. "Их Засаг" хуульд ан амьтныг авлах, хамгаалах асуудлыг хуульчилсан зүйл заалт лүгээ холбогдуулан "Монголын нууц товчоо"-нд тэмдэглэсэн нэгэн сонирхолтой баримт байгааг иш болговол Өгэдэй хаан /1228-1241/ өөрийн хаан байсан үеийн дөрвөн гавъяа, дөрвөн бурууг өчихдөө буруугийн нэг нь "тэнгэр газрын заяагаар төрсөн гөрөөсийг бусад ах дүү нарын нутагт очих болуузай гэж харамлаж, шавар хэрэм бариулж, ах дүү нараас гомдох үгийг сонсов, би. Энэ бас нэг буруу бий" /7,254/ хэмээн өгүүлжээ. Үүнийг доктор О.Амархүү эрэгцүүлэн тунгаагаад, Өгэдэй хаан ан амьтныг байгалийн жам ёсоороо нутаглах боломжийг хааж, тэдгээрийг хувийн өмч мэтээр ашиглах ёсгүй гэдгийг ухамсарлаж, хуулийг дээдлэн сахих учиртайг илтгэсэн хууль цаазны ач холбогдол бүхий зүйл гэж үзвэл зохилтой хэмээжээ. /1,30/. Үнэхээр ч хааны зарлиг учраас хууль зүйн учир холбогдолтой болох нь гарцаагүй.

Монголчуудын байгаль хамгаалах эрх зүйн уламжлал Их Юан улсын үед улам гүнзгийрэн хөгжжээ. Энэ тухайд нэн ялангуяа Хубилай хааны /1260-1294/ батлан гаргасан "Их Юаны нэвтэрхий хууль"-ийг онцлон дурдууштай. Эл хуульд газар нутаг, хөрс, ус, ой мод, ан амьтныг хамгаалах ан ав хийх, ой хээрийг түймрээс хамгаалахтай холбоо бүхий эрх зүйн хэм хэмжээ тусгагдсан нь "Их Засаг" хуулийг бараг хуулбарласан шинжтэй байна. Харин ойжуулах, цэцэрлэгжүүлэхтэй холбоо бүхий заалтуудыг шинээр томъёолж, ан ав хийх журам, дүрмийг нарийсгажээ. 1924 онд батлан соёрхсон хууль цаазны нэгэн сурвалжийн 38 дугаар бүлэгт: хун, усан тас агнахыг хориглоод, 59 дүгээр бүлэгт ой мод тарьж, цэцэрлэг байгуулах, хот тосгон, дэн буудал гол мөрөн, нуурын зах хөвөө, түргэн дамжуулах өртөө замын хажуугаар тус тус мод тарьж, орон нутгийн эрх баригчдаар хамгаалуулах байхаар заажээ. Улмаар тарьсан мод цэцэрлэг нь орон нутгийн цаг уурт таатай нөлөөлж, хүн ардын эрүүл мэндэд ашигтай тул хаврын цагт хонхорцогт мод, хайлаас тарих, тухайн хөрөнгийг гүүр барих, далан

цогцлох зардлаас гаргаж тарьсан модыг эрх бүхий хүмүүс малаар гишгүүлэн сүйтгэвэл ял хэлэлцэн торгох, тарьсан модоо сайтар хамгаалж байхыг үүрэг болгоод "... ой мод их болвоос алба аминд цөм ашигтай, агаарын зохимжийг үзэж хавар тарьсугай" /14,65/ гэжээ.

Өртөө замын хажуугаар мод тарьсан нь зун наранд халахгүй, өвөл цас дарвал ээрэм цагаан талд зам алдаж төөрөхгүй таатай юм гэж 1272 онд Монгол газраа 25 жил суугаад 1297 онд буцсан Итали улсын Венец хотын ирсэн Марко Поло бичсэнийг үзвэл дээр дурдсан хууль амьдралд хэрэгжиж байсны тод илрэл юм.

Хубилай хаан ан агнах хугацааг товлон тогтоосон зарлиг буулгаж, түүнийгээ хэрэгжүүлэхийг чанд шаарддаг байсан тухай сонирхолтой баримт сэлтийг Марко Поло өөрийнхөө номондоо дурдан бичсэн байна. Уг зарлигт "Их хааны захиргааны бүх газар нутагт... гурван сараас XII сар хүртэл ан амьтан үржиж төллөх үед ямар ч хан ван, ноёд, сайд ер хэн хүн бүх төрлийн ан амьтан, марал буга, туулай, чандага, зээр гөрөөс мэтийг авлахыг хориглоно. Хэрэв зөрчвөл хатуу цээрлүүлнэ" /8,111/ гэж заажээ. Энд ан амьтан үржин төлжиж, өсөн нэмэгдэх явдлыг чухалчлан үзээд, хориглосон хугацаанд ан ав хийхгүй байх, хуулийн өмнө иргэн бүр тэгш эрхтэйг тунхагласан байна. "Их Юаны нэвтэрхий хууль"-д эмхтгэгдсэн эл зарлиг дараа дараачийн хаадуудын үед ч уламжлагдан чанд мөрдөгдсөөр байжээ. Хубилай сэцэн хаан байгаль орчны цаг уурын өөрчлөлтийг урьдаас танин мэдэж, түүнтэй зохицон аж төрөх арга ухааныг ихэд эрхэмлэн, эл хэрэгтээ зурхайн ухааныг ашиглаж байлаа. Ингэснээр байгалийн болзошгүй аюулаас ард олныг урьдчилан сэрэмжүүлж, байгаль орчинтой зохицон амьдрах арга ухаанд илүү сургаж байсан байна.

Их Юан гүрний үеийн монголын газрын харилцааны асуудал байгаль хамгаалах асуудалтай тодорхой хэмжээгээр холбогдох нь дамжиггүй. "Их Юаны нэвтэрхий хууль"-д суурьшин амьдрагсад тариалан эрхлэн хөгжүүлэхийн чухлыг цохон тэмдэглээд, ургасан тариа, төлжсөн үр, адуу малаар талхлан гишгүүлэх буюу идүүлэх сүйтгэхийг хатуу хориглосон байна.

Улс төрийн бутралын үеийн байгаль хамгаалахтай холбоотой хууль цаазны нэн чухал сурвалж бол Алтан ханы /1507-1582 он/ цаазын бичиг юм. Уг хуульд байгаль хамгаалах талаарх тал нутгийнхны хэв хууль бараг тэр хэвээр бичигт буулгасан шинж илэрдэг.

Алтан хааны цаазын бичигт ой, хээрийг гал түймрийн аюулаас хамгаалах урьд байсан хуулиудын эрх зүйн хэм хэмжээ уламжлагдан тусгагдаж хуульчлагдсаны зэрэгцээ гал түймрийг "муу санааны үүднээс буюу зориудаар" тавьсан үйлдийг шинээр нэмэн оруулж, үйлдлийн субъектив талын санаа зорилгыг илүү тодруулж өгсөн байна. Энэ хуулийг мөн шинэтгэлийг хүндрүүлэх зарчим барьж боловсруулжээ. Тухайлбал, хэрэг үйлдсэн этгээдийг "... нэг хэсэг жанчиж өсөн өсөн малаар торгоно" /9,127/ гэж заасан нь торгуулийн хамгийн дээд хэмжээ тогтоосон хэрэг юм.

"Их Засаг", "Юан улсын нэвтэрхий хууль" зэрэгтэй харьцуулан үзэхэд Алтан хааны цаазын бичигт ан амьтныг хамгаалах хэм хэмжээ илүү өргөн цартай тусгагдсан төдийгүй, нэлээд иж бүрдэл шинжтэй байна. Уг цаазын бичгийн хулгайн хэргийн тухай заасан дөрөв дэх хэсгийн 37-39 дүгээр зүйлүүдэд баавгайн арьс, усны шувууны өд, цагаан үнэг, чоно, баруун зүгийн тарваганы болон бусад араатан амьтны арьсаар хийсэн дахыг хулгайлсан бол морь, үхэр, хонь, ямааны аль нэгээс эхлээд гурван өсөн малаар торгохоор тогтоосон нь дээрх дүгнэлтийг улам лавшруулан нотолж байна. Энэ үеэс ес торгох ял нэлээд цэгцэрч, монгол хуулийн шийтгэлийн гол хэм хэмжээ болжээ. "Алтан ханы цаазын бичиг"-ийн ес дэх хэсэг нь Монгол нутгийн уугуул нэн ховор болон

## *Байгаль хамгаалах түүхэн уламжлал*

ховордсон ан амьтныг агнаж авлахыг цаазалж, цаашид олшруулан өсгөж хамгаалахад чиглэгджээ. Эл хуулиар төрийн хамгаалалтанд авсан ариун догшин амьтны тоонд өдгөө “Ан агнуурын тухай” хуулиар нэн ховор амьтанд тооцон хамгаалж буй тахь, хандгай, хүдэр, ховор амьтанд тооцогдсон хулан, янгир, халиун буга зэрэг оржээ. Уг цаазын бичгийн 91-95 дугаар зүйлд: “Хэн нэгэн хүн хулан, тахийг хамаа бусаар албаас буруутай этгээдийг морь тэргүүтэй таван малаар, хандгай, зээрийг /эр, эм/ албаас тэрхүү буруутай хүнийг хонь тэргүүтэй таван малаар, тэх, ямаан гөрөөс /янгир/ ба хүдэр алсан бол тэрхүү зөрчил гаргасан хүнийг ямаа тэргүүтэй таван малаар, буга согоо, бодон гахай албаас буруутныг үхэр тэргүүтэй таван малаар, элбэнх, дорго, тарвагыг тогтоосон журам зөрчиж алсан хүнийг хонь тэргүүтэй таван малаар торгоно” /9,134/ гэж заажээ. Энд “хэн нэгэн хүн хамаа бусаар” гэсэн үгийг хэрэглэсэн нь тахь, хулан агнах явдал бүрмөсөн хориотой байсныг тус тус зориуд анхаарч, хууль зохион батлах үйл ажиллагааны нарийн чанд байдлыг хатуу мөрдөж байсныг бас нотолж байна. /1,37/ Ийнхүү Алтан ханы тогтоосон хууль бол урьд, хожид үйлчилж байсан хуулиудад байгаль орчныг хамгаалах талаар гарсан хэм хэмжээ, заалтуудыг их, бага ямар нэг хэмжээгээр тусгаснаараа өнгөрсөн үеэсээ залгамж гүүр, ирээдүйн төлөв байдлаараа тулгуур суурь болох эрх зүйн гол чухал баримт бичиг байлаа.

XVI зуны үед гарсан “Хутагтай сэцэн хунтайжийн шашны цааз” ч гэсэн адуу мал алж хойлого хийдэг бөөгийн шашны бурангуй ёсыг халах, амьтны амийг таслахыг аль болохоор тэвчих зэрэг энэрэнгүй үзэл номлолыг шингээснээрээ байгаль орчныг хамгаалах агуулгатай байсан гэж хэлж болно.

Улс төрийн бутралын үеийн хууль цаазны нэгэн чухал дурсгалт бичиг бол 1970 онд Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг-Харбухын балгаснаас олсон үйсэн дээр бичсэн XVI зууны II хагасаас XVII зууны 40-өөд он хүртлэх үеийг хамарсан хууль цаазууд юм. Үүнийг олсон монголын нэрт түүхч Х.Пэрлээ эдгээр үнэт баримт сэлтээ 1973 онд “Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн дурсгалт бичиг” нэртэйгээр хэвлүүлжээ. Эл цаазад бэлчээр нутаг, ус ашиглах явдлыг нарийн зохицуулж, байгаль хамгаалахад чиглэгдсэн зүйл заалтууд багагүй оруулсан байна. Тухайлбал, ус ундааг цэвэр ариун байлгах зорилго бүхий “ус буртаглавал хул морь, үхэр ав, үзсэн гэрч үхэр ав” гэсэн заалт тааралдаж байна. Мөн ан амьтныг хамгаалах асуудалд ихээхэн анхаарал тавьжээ. Араатан жигүүртэнд урхи, тор, хавх хэрэглэх, амьтныг нүхэнд нь утаж алахыг тодорхой тохиолдолд хориглосон байна. Мөн аливаа амьтныг мориор гишгүүлэх зэргээр энэлгэн агнахыг хориглож, зөрчвөөс хатуу ял оноохоор заажээ.

Халх, Ойрад, Манж чин улсын түрэмгийлэл шууд нүүрлэн ирсэн үе-1640 онд халх, ойрадын бүх ноёдыг төлөөлсөн чуулган болж, “Дөчин дөрвөн хоёрын их цааз” [10] буюу “Монгол-Ойрадын хууль”-ийг баталсан юм. [11] Эл хуульд юуны өмнө байгаль хамгааллын асуудлыг нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, төрөлх нутгаа хайрлан хамгаалах үзэл төлөвшүүлэх, хаад ноёдын онцгой эрх дарх, зугаа цэнгэлийг хангах газар нутгаа ариун дагшин хэвээр нь байлгах явдалтай холбож, энэ чиглэлээр эрх зүйн зохих хэм хэмжээ тогтоож өгчээ. Тухайлбал, гал түймрийн аюулаас сэрэмжлэх, хамгаалах талаар өмнөх хуулиудын залгамж чанарыг хадгалсан шинжтэй боловч, тогтоосон хэм хэмжээ нь арай өөр өвөрмөц агуулгатай байна. Уг хуульд нүүж явахдаа гэрийнхээ буурин дээр үнс нурамдаа гал, цог үлдээлгүй сайтар унтрааж байх, гал түймэр унтраахад идэвх зүтгэл гаргасан буюу гал, усны аюулаас эрдэнэт хүмүүний амь насыг аварсан хүнийг хөхүүлэн урамшуулах журмыг монголын хууль цаазны түүхэнд анх удаа хуульчилж өгсөн онцлогтой байна. Бүр тодруулж хэлбэл, айл нүүсэн хойно бууц нутгаас нь түймэр дэгдвэл буруутай эзнийг нь баалан шийтгэх, гал, усны аюулаас хүний амь насыг аварсан бол таван толгой малаар хөхүүлэх,

## *Байгаль хамгаалах түүхэн уламжлал*

хэрэв тусалж байсан хүн амь үрэгдвэл гэр бүлд нь есөн есөн мал өгөх, түүнчлэн өш хонзон санаж зориудаар гал түймэр тавьсан бол тусгайлан хамгийн хүнд шийтгэл оногдуулахаар эл хуульд заажээ.

Газар орноо үл бохирдуулан цэвэр ариун тансаг байлгах явдалтай холбогдуулж, уг хуульд сонирхол татахуйц хэм хэмжээ тогтоосон байна. Ган гачиг, зуд турхан, цасан шуурга, ширүүн бороо, хүйтэнд нэрвэгдэж үхсэн малын сэг зовлогыг уг малын эзэн хүн арав хоногийн дотор авч, орчноо цэвэрлэж байх ёстойг хуульчлаад, үүнийг хийж гүйцэтгээгүй буруутай этгээдийг гунжин үнээгээр торгохоор заасан байна. Эдүгээ ч энэ заалтыг холбогдох хуулинд тусгах нь ажил хэргийн ач холбогдолтой юм.

Мөн хуулийн ав хомрогын тухай өгүүлсэн хэсэгт хаад, ноёдын ан агнах газрыг тусгайлан зааж өгч, үүнийг хамгаалах хэм хэмжээг тогтоосон байна. Энэ нь нэг талаас ноёд язгууртны эрх дарх, мэдлийг өргөж өгч байсан, нөгөө талаас байгаль хамгаалах асуудалтай холбон тэдэнд хүндэтгэл үзүүлж, бас хариуцлага хүлээлгэж байсан хэрэг юм. Тухайлбал, ийм газар ав хомрого хийх эрхгүй, тийм зиндааны бус хүн орж ан агнавал тэмээ тэргүүтэй есөн малаар торгож байх тухай уг хуульд заажээ. Учир нь иргэд зэрэг зиндаагаараа эрх эдлэхийн хамт бас хариуцлага хүлээх ёстойг ийнхүү хуульчилжээ. Мөн зартай, заргүй сааль тавихыг /ан амьтны ус, хужир мараанд очих гүйдэлтэй газар байрлуулдаг тусгай оньстой зэвсэг. Зох./ хориглосон байна. Харин ан амьтныг хамгаалах талаар нийгэм даяар түгээмэл мөрдөх эрх зүйн хэм хэмжээний хувьд гэвэл “хэн нэг хүн авын журмыг эвдвэл” таван мориор торгож шийтгэх заалт өгснөөр шийдвэрлэжээ.

Хүн, байгалийн харьцаанд тохиолдож болзошгүй зүйл, эрхэлж байсан аж ахуйн онцлогоос үүдэлтэй орсон буур, улангассан бух, догшин азарга зэрэг гэрийн мал боловч, янз бүрийн шалтгаанаас болж догширсон амьтдыг эзэн нь харж цагдаж байх, тэдгээрээс хэн хүнгүй болгоомжлох, галзуу чоно, нохой мэт араатан амьтдаас урьдчилан сэргийлэх, тэдэнтэй бүх нийт эрх шагийн үүднээс тэмцэх, хүний амь насыг хамгаалах зэрэг заалт хуульд тусгагдсан байна. Энэ нь хуулийн энэрэнгүй байх зарчим тодорхой тохиолдолд үйлчилж байсныг харуулна.

Монгол, Ойрадын хууль нь харийн түрэмгийлэл нүүрлэн ирсэн хүнд үед хүн ардын сонор сэрэмжийг дээшлүүлэх, эв нэгдлийг хангах улс төрийн ач холбогдолтой төдийгүй төрөлх нутгийнхаа онгон байгалийг хамгаалахтай холбоо бүхий хуучин буурь нутагтаа галыг сайтар унтрааж нүүж байх, ой, хээрийн түймэрийг унтраах явдалд хүчин зүтгэсэн хүмүүсийг хөхүүлэн урамшуулах, хаад, ноёд, ихэс, дээдсийн ан ав хийхэд зориулсан газрыг тусгайлан тогтоож, тэдний хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх зэрэг журам, шийтгэлийн шинжтэй асуудлыг анх удаа хуульчилж өгснөөрөө монголчуудын байгаль орчноо хамгаалах цааз эрхэмжийн хөгжлийн бүхэл бүтэн нэгэн үеийг төлөөлөн харуулах чадамжтай хууль зүйн баримт бичиг юм.

XVII-XVIII зуунд Монгол орон Манж чин улсын эрхшээлд бүрэн орсон билээ. Гэхдээ манж нар Монголд шууд өөрийн хууль цаазыг тогтоогоогүй, Энх-Амгалан хаан “шинэ дагасан халх нарыг түр тэдний хууль ёсоор болтугай” /12,5/ хэмээн зарлиг буулгасан байна. Иймээс 1709-1795 оны хооронд халхын хаад, ноёд, шашны томоохон зүтгэлтнүүд бүгд 20 гаруй удаа янз бүрийн газар цугларан хуралдаж, “Халх журам” хэмээх хууль цаазны бичгийг хэлэлцэн тогтоосон байна. “Халх журам” нь 1789 онд Манж нар “Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг”-ийг зохион гаргаж, дагаж шийтгүүлэх болсноос хойш нийтээрээ дагах нь аажмаар багасч, зөвхөн Их шавийн дотор /Богд гэгээний шавь. Зох./ хүчин төгөлдөр мөрдөгдөх болсон байна.

## *Байгаль хамгаалах түүхэн уламжлал*

“Халх журам” бол Монгол орон Манж чин гүрний зах хязгаар болон хувирсан үеийн нийгмийн амьдралын олон талыг хуульчлан тусгасан янз бүрийн төрлийн эрх зүйн хэм хэмжээний цоморлиг бөгөөд түүний дотор байгаль хамгаалах асуудал томоохон байр эзэлж байна. Юуны өмнө, эл хуулинд ой хамгаалах асуудал өмнөх хуулиудаас илүү нарийвчлан тусгагджээ.

“Халх журам”-ын 126 дугаар зүйлд хүрээ зассан /байгуулсан/ газарт хуурай, нойтон мод огтлохгүй, хүрээний захаас гадагш бол өндөсч харваас нааш газарт нойтон мод огтлохгүй байхыг тус тус хориглоод, хэн хүн мод огтолбол багаж болон биедээ авч яваа эд юмыг бүгдийг хурааж авч байх тухай заажээ. Харин 127 дугаар зүйлд мод огтлохгүй байх зайг “хоёр хар, цагааны газраас нааших” гэж өөр үгээр тодорхойлжээ. Эл асуудлыг судалсан манай хуульч эрдэмтэд 126 дугаар зүйлийн тодотголыг “өндийн харахад нүдний хараа хүрэх тийм зайны газар” /1,40/, 127 дугаар зүйлд өгүүлснийг “энгийн нүдээр малын зүсийг ялгаж чадах тийм хэмжээний газар” /1,41/ гэж тайлбарлажээ. Бидний бодлоор бол 126-127 дугаар зүйлд дурдсан энэ хоёр тодотгол ижил утгатай ойлголт. Монголын түүхийн сурвалж бичгүүдэд “Хүрээний захаас хар, цагааны газар” хэмээхийг хүрээ, сууринаас эхний ой хүртэл тэр модтой уулнаас дахин модгүй цагаан цулгүй газар буюу уулын ам, хөндий өнгөрөөгөөд дараагийн ойн зах хүртэл газрыг ойлгож иржээ. Харин “өндөсч харах” гэдэг нь эхний модтой уулнаас өнгийхөд харагдах модтой уулнаас гэсэн санаа юм.

“Халх журам”-ын 126 дугаар зүйлд нойтон мөчир, нойтон модны ёсоор адил цаазтай гэж тэмдэглэсэн нь нойтон мод гэдэг ойлголт угаасаа ид ургаж, цэцэглэж байдаг учир мөчирч ялгаагүй, ийм учраас аль болох хатсан буюу өгөршсөн модыг хэрэгцээндээ хэрэглэхийг хуульчилсан хэрэг юм.

Уг хуулиар “гурван этгээдээс элч гарган ажиллуулж, тухайн хориглосон үйлдийг зөрчсөн эсэхийг шалгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах эрх зүйн хэмжээ тогтоосон нь тухайн үедээ цоо шинэ зүйл байв.”

Гурван этгээдээс гэдэг нь хүрээний захиргаа, шашин сүм хийд, уг хүрээнд оршин суугч энгийн иргэдээс тус бүр нэг төлөөлөгч оролцох ёстойг хэлж байна. Тэдгээр элч нар бол өдгөөгийн ой хамгаалагч, байцаагчийн үүргийг хүлээж байсан бололтой. Хот суурин болон түүний ойролцоо газрын ой модыг хамгаалах журам тогтоохдоо юуны өмнө, залуу зулзган ойг ариглах тухай “... нойтон модыг хуга дайрсан бол сүхийг ав” /12,32/ гэж онцлон заажээ.

“Халх журам”-д ан амьтныг хамгаалах тухай асуудал өмнөх хууль цаазын баримт бичгүүдэд байгаагүй өргөн цараатай тусгагдсан юм. Тухайлбал, уг хуулийн 127 дугаар зүйлд: “Хүрээ хаа зассан газраас зэрэгчлэн хойт бие нь Сэлэнгээс уламжлан, Ар Тойлб, Намын даваа, Нарийн, Орхон, Чандагатын хяр, Шувуутайн хяр, Сангийн даваа, Цулхад зэргээс нааших газрын амьтныг алахгүй, хэрэв алваас хуучин цаазын ёсоор болгож бай.” /12,32/ гэж заасан нь маш өргөн уудам нутагт ан агнахгүй байхыг хуульчлан тогтоосон хэрэг юм. Хуулийн 128 дугаар зүйлд: “ер сар бүрийн шинийн найман, арван таван, арван гурван, хорин таван, гучин эдгээр өдөр юм бүү ал. Давж албаас мөн тэр алсан юмыг үзсэн хүн гэрчилж байж газрын газар хүрч ав” гэж заажээ. Эдгээр өдрүүдийг тохиолдлын шинжтэй сонгоогүй бөгөөд зурхай, ном үзэж тогтоосон нь ан амьтныг хамгаалах асуудлыг сүсэг бишрэлээр дамжуулан бататгаж байсан хэрэг юм. Хуулийн зөвхөн энэ заалтын дагуу тооцоолж үзвэл сард 5 өдөр, жилдээ 60 өдөр буюу хоёр сарын хугацаанд ан агнахгүй байсан байна. Үүн дээр хуулиар тогтоосон ан агнахгүй байх улирал, бусад хугацааг тоолбол чамгүй олон хоногийн хязгаарлалт тогтоож, амьтны амь тэвчин буян үйлдэж байсан хэрэг юм. Энэ нь бүх төрлийн ан амьтныг хамаарч байгаагаараа улам ч чухал ач холбогдолтой бөлгөө.



## *Байгаль хамгаалах түүхэн уламжлал*

Амьтныг хамгаалах талаар анхаарч үзүүштэй нэгэн эрх зүйн хэм хэмжээг 129 дүгээр зүйлээр тогтоожээ. Үүнд: "эмгэг өвчингүй, морь, хонгор галуу, могой, мэлхий, ангир, нялх янзага, болжмор, нохой эднийг бүү ал. Алсныг үзсэн хүн үзвээс морь ав" /12,33/ гэжээ. Энд дурдсанаас агнуурын гэж үзэж болох нь зөвхөн хонгор галуу байгаа бөгөөд бусад нь Монгол орны хувьд хэдийнээс агнуурын онц ач холбогдолгүй ан амьтдыг нэрлэжээ. Энэ нь монголын хууль цаазны хөгжилд гарсан цоо шинэ үзэгдэл юм. Ийнхүү монголчуудын хувьд агнуурын ач холбогдолгүй могой, мэлхий, ангир, болжмор зэрэг амьтныг хамгаалах хууль зүйн үндэслэл монгол оронд XVIII зууны эхнээс тавигдаж байсан нь амьтны аймгийг хамгаалах талаар эцэг өвгөд маань үнэхээр их зүйлийг бодож, сэтгэж, хийж байсныг илтгэнэ.

"Халх журам"-д усыг бохирдлоос хамгаалах хууль цаазны өмнөх үеийн уламжлалыг хадгалсны зэрэгцээ усыг зөв зохистой ашиглах, эзэмших, худаг, булаг шанд зэрэг ус гаргасан, тохижуулсан тухайн хүний давуу эрхийг анх удаа хуульчилж өгчээ. Энэ хуулийн 173 дугаар зүйлд "Мэдээ байж шоглож ус бохирдуулбал шүдлэн морь, үхэр хоёрыг ав. Үзсэн гэрчид үхэр өг " гэсэн санаатайгаар үйлдсэнийг тодруулсан уламжлалт шинжтэй заалт байхын зэрэгцээ "Хүний шинэ ухсан зассан усыг булаацалдаж хэрэлдвээс нэг хязаалан морь ав. өөрийнхөө малыг усалж дууссан боловч усаа эс өгвөөс мөнхүү морь ав" /12,39/ гэж заасан нь усыг зохистой ашиглах асуудлыг хөндөн тавьсан хэрэг юм. Энд говь, тал, хээр нутагт ус ховроос болж олонтаа гардаг маргааныг буруутай этгээдэд эд материалын хохирол учруулах замаар зогсоох арга сэджээ.

"Халх журам"-д гал түймэртэй тэмцэж ирсэн өмнөх үеийн хууль цаазны уламжлалаа харгалзан үзэхийн хамт бас улам тодруулж, нарийвчилсан шинжтэй заалтуудыг тусгасан байна. Уг хуулийн 176 дугаар зүйлд хэн хүн түймэр алдвас хэдэн хүн ч байсан хүн бүрээс морь аваад юуг түлвээс таваар торго, алдагч хүн өөрөө унтрааваа торгуульгүй" /12,40/ гэж заагаад түймэр гаргасан этгээдийг мэдэж гэрчилсэн, гал унтраахад зүтгэл гарган оролцсон хүмүүсийг хөхүүлэн урамшуулж байх журам тогтоосон байна. Түүнчлэн 177 дугаар зүйлд "Хэн хүн нүүсэн нутгийнхаа галыг унтраа, эс унтраавал шүдлэн морь өгч бай" /12,40/ гэж заасан нь "Монгол-Ойрадын хууль"-ийн өв уламжлалыг хэвээр хадгалсан хэрэг юм. Харин уг хуулийн заалтыг ердийн нэг хуулбарласан хэрэг биш, харин тодруулан баяжуулж, нүүсэн нутгаас 3 хоногийн дотор гал гарвал тэрхүү нүүсэн айлын эзэнтэй дээрхийн адил хариуцлага тооцох, хэрэв 3 хоногоос цаашхи бол тооцохгүй байх тухай хугацааг нарийвчлан тодорхойлжээ. Энэ нь хууль цаазны хариуцлагыг бодит үнэнтэй нягт холбон үзэж байх зарчмыг чанд мөрдөж байсны нотолгоо юм. /1,43/

"Халх журам"-д цааш нь гүнзгийрүүлж заахдаа: Улсын дунд /Айл саахалтын дунд гэсэн утгатай. Зох./ түймэр шатвас түймрийг аль ойр байгаа улс нь /хүмүүс нь/ зартай, заргүй унтраа. Зар сонсож байж ноён хүн эс мордвоос морь ав, ямбатан сайд нараас үхэр ав, энгийн хүнээс хонь ав. Хэн хүн зар тасалбаас энэ зэргээр баалж бай. Хүн үхвээс хүн алсны анзуу болоод ортой" /12,40/ гэжээ. Энэ нь түймэр гарсан зарыг олон түмэнд яаралтай хүргэж, дав даруй олны хүчээр шуурхай унтраах, түймрийн дайчилгаа явуулж байх, түүнээс хойш суусан хүмүүст хариуцлага хүлээлгэдэг хууль зүйн өнөөгийн тогтолцоо бүр XVII зууны эхэн үед эх үүсвэрээ тавьж бүрэлдэж эхэлснийг харуулж байна.

"Халх журам"-ын зарим зүйл, заалтаас үзэхэд, аймаг, хошуу захирсан ноёд язгууртнууд өөрийнхөө эзэмшил нутагт зарим үзэсгэлэн төгөлдөр газрыг онголон хамгаалах эрх эдэлж байсан бололтой. Эл хуулийн 168 дугаар зүйлд "Ихэсийн онголсон газар хоёр хар, цагааны газраас дотогш хүн бууж мал нь хөндвөөс малын эзнээс морь авч бай" /12,39/ гэж заасан нь газар нутгийг дархлан

## *Байгаль хамгаалах түүхэн уламжлал*

хамгаалах агуулга бүхий бөгөөд тийнхүү онголох эрх нь тайж, тавнан, сайд, ноёдн хэргэм зэрэгтэй хүмүүсээр уламжлагдан, Манжийн эзэн хаанд хүрч шийдэгдэж байсныг нотолж буй хэрэг юм. Тухайлбал, /Их Хүрээний сайд Юндэндорж, ноён Санзайдорж нар санаачлан, Богд хан уулыг /Өдгөөгийн Монголын нийслэл ард талд нь оршдог. Зох./ дархан цаазтай болгох асуудлыг Манж чин улсын эзэн хаанд өргөн мэдүүлэхэд 1779 онд ёсоор болгон зарлиг гаргажээ. Мөн зарлигаар Хан Хэнтий, Отгонтэнгэр, Дарь /Алтан/ овоог нэгэн хамтад дархан цаазтай болгосон байна. “Халх журам”-аар хүрээ хийдэд газар эзэмшүүлэх харилцааг зохицуулсан нь бурхны шашныг хөхүүлэн дэмжих бодлогын нэгэн илрэл байлаа.

“Халх журам” бол байгаль хамгаалах харилцааг зохицуулсан агуулгаараа өмнөх бүх хуулиудаас илүү давуу бөгөөд хот, суурин газрын ногоон бүсийг тодорхой зааглах агнуурын зориулалтгүй жижиг амьтан, шувуудыг хайр найргүй алж устгахыг цаазлах, ан амьтан агнахыг хориглосон хугацааг монголчуудын цаг хугацааны дадсан ойлголтоор томъёолох, ус анх гаргаж тохижуулсан хүний давуу эрхийг хуульчлах, түймэрийг хамгийн түргэн шуурхай унтраах арга зам, журмыг тодотгох, үзэсгэлэнт газрыг онголон дархлах асуудлыг дээш тавьж шийдвэрлэх эрхийг орон нутгийн ноёд язгууртнуудад олгох, хүрээ хийдийн эзэмших эрхийг хангаж, хамгаалах зэрэг эрх зүйн олон чухал хэм хэмжээг шинээр тогтоосноороо нэн чухал ач холбогдолтой хууль юм.

1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын үрээр монголчууд тусгаар тогтнолоо дахин сэргэж, шинэ тулгар улс тогтносоноороо эрх зүйн шинэтгэл хийж эхэлжээ. Улсын хууль зохиох комиссийг байгуулж ажиллуулан, 1915-1918 онуудад 65 дэвтэр бүхий “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” хэмээх нэгдмэл хуулийг Богд хаанаар батлуулан хэрэгжүүлж эхэлсэн билээ. Эл хуулиар байгаль орчныг хамгаалах асуудлаар эрх зүйн олон хэм хэмжээг анх удаа шинээр тогтоож өгсөн юм. Үүнд:

- Газар, түүний баялаг улсын (хааны) өмч гэж үзээд, хариуцан хамгаалах үүрэг, хариуцлагыг орон нутгийн эрх баригчдад олгожээ. Уг хуулийн “Түшмэлийн засаг” хэмээх X дэвтэрт аливаа алт, мөнгөний зэрэг орд, элс гарах газрыг харъяа засаг, түшмэл нар хариуцан хамгаалж байх тухай заагаад хэрэв тэдгээр баялгийг монгол хүмүүс болон гадаадын хүн, мөн хоорондоо нийлж хулгайн аргаар ашиглавал байцаан шийтгэх нарийн журам тогтоожээ. Хэрэв хулгайчдыг барьж илрүүлэн байцаан шийтгэж чадаагүй алдсан бол тийнхүү хариуцлага алдсан засаг, түшмэл нарыг өсөн малаар торгох, цалин пүнлүүг нь 3 сараас 2 жил хүртэл хасах, түшмэлийг албанаас халах, 100 хүртэл ташуур занчих ял шийтгэлийн аль нэгийг хэргийн байдлыг харгалзан оногдуулж байх тухай заасан байна. /13, 53-54/ Түүнчлэн “Битүү хулгах нь” /хулгайлах гэсэн үг. Зох./ хэмээх 51 дүгээр дэвтэрт тариа, хээрийн амуу, буудай, сонгино, жимс, уул хээрийн өвс, шарилж, мод чулуу зэрэг байгалийн баялгийг хүн сахин харж байгаа эсэхийг харгалзахгүйгээр хулгайлсан хүнийг барьж шийтгэх, мөн аливаа алт, мөнгө, тугалган ус зэрэг зүйлсийн ордыг хулгайлан ухсан байвал буруутай хүний хэргийн хөнгөн хүндийн байдлыг харгалзан 60-80 өдөр дөнгө дөнгөлүүлж, 100 ташуур занчих, хулгайлсан баялгийг хурааж авах ял шийтгэл оногдуулж байхаар тогтоожээ. /13, 214/ Бас өөр нэг анхаарал татахуйц хууль зүйн хэм хэмжээ гэвэл, орд гарах уулын эзэн /харъяат засаг ноён, түшмэл/ цаазыг зөрчиж, ардыг удирдаж, орд ухваас түүнийг хулгайн хэрэг гэж үзэж, 35 өдөр дөнгө дөнгөлүүлж, 90 ташуур занчих ял шийтгэл оногдуулах, мөн ийм хэргийг үзэж мэдсэн гэрч эс гэрчилбээс түүнийг ялт хүн хэмээн үзэж шийтгэж байх тухай бас заасан байна. Эдгээр

## *Байгаль хамгаалах түүхэн уламжлал*

заалт нь улс орныхоо байгалийн баялгийг соргоогоор хамгаалах ёстой төрийн албан тушаалтан, ард иргэдийн үүрэг, хариуцлагыг өндөржүүлснээс гадна шинэ тулгар төр байгалийн баялаг ашиглах элдэв татвар, хураамж авах дүрэм журам гаргаснаа мөрдүүлэх, мөн зарим шунахай ноёд, түшмэд олз ашиг хайсан харийн хүмүүстэй хуйвалдан, ашигт малтмалын орд газрыг зааж өгөх, албат харъяатаа дайчлан хамтран ухалцах болсон цаг үеийн байдлаас урган гарсан шинэ харилцааг зохицуулсан хэрэг байлаа. Ийнхүү алт, мөнгө, тугалга, элс хайрга зэрэг газрын дээрх болон далд ашигт малтмалыг хамгаалах зүй зохистой ашиглах асуудлыг монгол төрийн түүхнээ анх удаа энэ хуулиар зохицуулсан байна.

- Энэ хуулинд гадаад улсын иргэдэд бэлчээр ашиглах, тариа ногоо тарих, барилга байшин барих, хашаа хатгах газрыг түрээсээс эзэмшүүлэн олгох, эрх зүйн үндэсийг анхлан бүрэлдүүлжээ. Тухайлбал, “Гааль татвар” хэмээх 13 дугаар дэвтэрт гадаадын хүн монголын олон хошуу, шавийн нутагт мал үржүүлэн адуулах болбоос бэлчээрийн гааль хураан авч байх, мөн гадаад улсын худалдаачид Монголын газар нутагт хашаа байшин барьж суурьшвал тэрхүү хашаа байшингийн эзэлж буй хэмжээгээр газрын гааль авч байх тухай заасан байна. /13, 67/ Чингэснээр гадаадын иргэд, ялангуяа монгол нутагт дураар сэлгүүцэх, суурьших, ногоо тариа эрхлэх явдлыг журамлажээ.
- “... Хууль зүйлийн бичиг” –т тариа ногоо тарих явдлыг онгон тахилгат газар нутаг, малын бэлчээрт аль болох сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр эрхлэн хөгжүүлэх эрх зүйн үндсийг зохицуулж, газар тариалангийн үйлдвэрлэл, төрийн удирдлага, хяналтанд байх журмыг хуульчилж өгчээ. “Сангийн амуу” хэмээх 12 дугаар дэвтэрт хүн ардын амьдрал ахуйг сайжруулах зорилгоор газар тариалангийн үйлдвэрлэлд сургах, газар хөрсийг хамгаалж, зохистой ашиглуулах үүднээс орон нутгийн эрхэм сүлд тахилга, малын бэлчээрт харшгүй газарт сангийн амуу тариалж байх, тариалах газрын нэр хэмжээг зургаар гаргаж Сангийн яамнаас зөвшөөрөл авах, тус яам уг газрыг 3 жилд нэг удаа магадлан шалгаж байх тухай заажээ. /13, 61/
- Газар зохион байгуулалтыг сайтар хийж, засаг захиргааны нутаг дэвсгэрийг зураглалаар тэмдэглэх, хил савлах хэмжээ, заагтай, төрийн зөвшөөрөл, хяналтад байх журмыг болон зурхайн аргаар цаг уурын мэдээг аль болох үнэн зөв гаргаж, өргөн олонд мэдэлж байх эрх зүйн үндсийг анх хуульчлан тогтоосон байна. Энэ тухай “Нутгийн хэргийн хууль” хэмээх 45 дугаар дэвтэр, “Цагийг уламжлах нь” хэмээх 29 дэвтэрт тодорхой заажээ. Уг хуулийн 29 дүгээр дэвтэрийн “Тэнгэрийн байдлыг зурж үзэх нь” гэсэн зүйлд: “Аливаа тэнгэрийн зурхай нар, сар барих гэрэлт одон гарах, наран хүрээлсэн, наран саран хосолсон зэрэг тэнгэрийн байдлыг шинжиж үзэх явдлыг Нийслэл хүрээний зурхай дацан зурж үзэгтүн” /13,126/ гэж тогтоогоод тэнгэрийн зурхай зурж, нар, сар барих зэргийг бодох, үзэх, сонсгон айлтгах, мэдүүлэх, зарлахыг алдах ташаарах болбоос аливааг 60 ташуур занчиж шийтгэхээр заажээ.
- Эл хуульд байгаль хамгаалах заншлын эрхийн хэм хэмжээг хуульчилсан томоохон хэсэг орсон нь “Тайх тахиглах ёслолын хууль” хэмээх 32 дугаар дэвтэр юм. Эл хуульд “Улс төрийн ёсонд хичээнгүйлэн тэнгэр газар, өвөг сүм, шорооны эзэн, тариалангийн эзний их мандалд өчин тайх ёслол бүхнийг нь олон харъяат газрын язгуураас явж ирсэн хуучин суртал ёсыг дагаж явуулагтун” /13,131/ гэж заагаад цааш нь Богд хан уул, хан Хэнтий уул, Отгонтэнгэр уулыг тайх ёслолын тухай заасан байна.

## *Байгаль хамгаалах түүхэн уламжлал*

Ер нь “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” нь 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалаар улс орон туурга тусгаар болсон зурвас үеийн нийгмийн харилцааг зохицуулсан эрх зүйн гол баримт бичиг төдийгүй, XX зууны Монголын хууль зүйн хөгжлийн эх үндсийг тавьж өгснөөрөө онцгой ач холбогдолтой юм. Энэ хууль байгаль орчныг хамгаалах тухайд л эл хэрэгт нутгийн захиргааны эрх баригчдын хүлээх эрх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, байгалийн баялаг, ашигт малтмалыг хамгаалах, зүй зохистой ашиглах, гадаадын иргэдэд газар, бэлчээрийг түрээслүүлэх, газар зохион байгуулалтаас урган гарсан олон асуудлыг журамлах, уул усыг онголон дархлах, уул овоо тайх тахилгах заншлын эрхийн хэм хэмжээг хуульчлах зэргээр Монголын төр, хууль цаазны түүхэнд урьд өмнө байгаагүй буюу бүрхэг байсан олон хэм хэмжээг шинээр тогтоосон байна.

Бүхэлд нь базаж хэлбэл, Монгол улс бол байгаль орчныг хамгаалах талаар нэн эртнээс зан заншил, шашин шүтлэг, хууль цаазны маш нарийн, онцгой өвөрмөц тогтолцоо бүрдүүлсэн цөөн тооны орнуудын нэг юм. Энэ бүхэн нь монгол хүний унаган байгальтайгаа өдөр тутам харьцахаас аргагүй ахуй амьдрал, сэтгэлгээ, арга ухаантай шууд холбоотойг тэмдэглэх хэрэгтэй юм.

### **Ишлэл, зүйлт**

1. О.Амархүү. Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил, хууль цааз. /Уламжлал, шинэчлэлийн асуудал/. УБ. 2000.
2. Монголын этнографийн асуудал. V боть. УБ.1974.
3. Монгол цэцэн үгийн далай. УБ.1964.
4. С.Бадамхатан. Хөвсгөлийн дархад ястан. УБ.1965.
5. Чингис хааны Их засаг хууль. УБ.1995.
6. Эзэн Богд Чингисийн “Их Засаг”. УБ.1995.
7. Монголын нууц товчоо. УБ.1990.
8. Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. /Аяны тэмдэглэл/. УБ.1987.
9. Ш.Бира. БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд. УБ. 1977.
10. Энэ хууль цаазны бичгийн үйлчлэх хүрээг 40 түмэн монгол, 4 түмэн ойрадын нутаг дэвсгэрээр үндэслэн тогтоосноос ингэж нэрлэжээ.
11. Энэхүү өгүүлэлд ашигласан ишлэлийг зохиогч өөрийнхөө хувийн архивт буй “Монгол-Ойрадын хууль” хэмээх гар бичмэлээс ашиглав.
12. Халх журам. УБ.1995.
13. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. УБ.1995.
14. Байгаль орчныг хамгаалахтай холбогдсон лекцийн эмхтгэл. УБ.1990он.
15. Монголчуудын байгаль хамгаалах ёс заншил, уламжлалаас. УБ.2001.